

2008.02.28

Дугаар 30

Зарим хадгаламж, зээлийн хоршоодод
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хоршооны тухай хуулийн 48¹.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж, холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу бүрдүүлж ирүүлсэн хавсралтад дурдсан нэр бүхий 2 хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн тайланг улирал бүр гаргаж, зохих журмын дагуу тогтоосон хугацаанд Хороонд ирүүлж, холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан хадгаламж, зээлийн хоршоодын удирдлагад үүрэг болгосугай.

3. Тусгай зөвшөөрөл авсан хадгаламж, зээлийн хоршоодын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Хадгаламж, зээлийн хоршоодын газар /Б.Мөнхжаргал/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

Монгол улсын Санхүүгийн зохицуулах
хорооны 2008 оны 30 дугаар
тогтоолын хавсралт

№	ХЗХ-ны нэр	Хоршооны дарга	Байршил	Хянасан байцаагчийн нэр
1	“Хас итгэл”	Н.Сандуйжав	Дархан-Уул аймгийн Орхон сум, Баян-Өлзийт хэсэг, 9-р цэцэрлэгийн 13 тоот	Л.Энхбаяр
2	“Ю Эс Ди Эм”	Б.Намхайнямбуу	БГД, 18 хороо, 18-36 тоот	Б.Пүрэв